



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



**СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН БОДИТ БУС ТӨЛӨВЛӨЛТ
НЬ АРВИЛАН ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛАХАД
НӨЛӨӨЛЖЭЭ.**



68

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/11

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов эрх үүргийн 2.4 дэх хэсэг "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Аймгийн сонгуулийн хороонд хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын дарга /Д.Соёлчхүү/-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /В.Жавзмаа/, аудитор /Б.Бямбатогтох/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

D:\my doc \bichig heregl\ tushaal \ 2021.doc

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/11 дугаар тушаалын хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Алдаа зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Хариуцагч байгууллага	Мөнгөн дүн /сая.төгрөг/
1	Шатахуун зарцуулалтын нормыг баталсан, тогтоосон дүнд үндэслэхгүйгээр өндөр дүнгээр тооцож, илүү зарцуулсан	01/61 ОРА-2021/38-13-ШТА-ГА	Аймгийн сонгуулийн хороо	1,168.1
2	Шатахуун зарцуулалтын нормыг баталсан, тогтоосон дүнд үндэслэхгүйгээр өндөр дүнгээр тооцож, илүү зарцуулсан	02/62 ОРА-2021/38-13-ШТА-ГА	Баян-Өндөр сумын сонгуулийн хороо	627.7
3	Шатахуун зарцуулалтын нормыг баталсан, тогтоосон дүнд үндэслэхгүйгээр өндөр дүнгээр тооцож, илүү зарцуулсан	03/63 ОРА-2021/38-13-ШТА-ГА	Жаргалант сумын сонгуулийн хороо	176.3
4	Аймаг, сумын сонгуулийн хороод нь сонгууль зохион байгуулах байр бэлтгэх болон болзошгүй зардлаас хөрөнгө авч, данс бүртгэлд тусгаагүй байна.	07/113 ОРА-2021/38-13-ШТА-ГА	Аймгийн сонгуулийн хороо	1,198.6
Нийт дүн				3,170.7

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	5
Хүснэгтийн товъёг	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	7
БҮЛЭГ 1. Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгох зардлыг бодитой, судалгаатай төлөвлөх шаардлагатай байна.....	9
<i>А.1. Улсын төсвөөс олгох сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлтийг бодитой, судалгаатай төлөвлөх шаардлагатай байна.</i>	9
<i>А.2 Аймгийн сонгуулийн хороо зардлыг журам, аргачлалын дагуу хуваарилсан байна.</i>	10
БҮЛЭГ 2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулахад анхаарч, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.....	12
<i>Б.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ч арвилан хэмнэлттэй зарцуулахад анхаараагүй байна.</i>	12
<i>Б.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнажээ.</i>	12
<i>Б.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.</i>	13
Холбогдох байгууллагын санал:	14
Саналд өгсөн тайлбар:	14

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОБГ	Онцгой байдлын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
САС	Сонгуулийн автоматжуулсан систем
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан төсөө	7
Хүснэгт 2	Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл	11

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн сонгуулийн хорооны төсөө, нэрсийн жагсаалтад бүртгэлтэй хүний тоо	8
Дүрслэл 2	Аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарилалт 2017, 2021 он	9

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 , Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Орхон аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасныг баримтлан гүйцэтгэлийн аудит хийлээ.
Аудитын зорилт	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Сонгуульд улсын төсвөөс олгосон зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх; • Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос аймаг, нийслэлийн сонгуулийн хороодод хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулан хэрэгжүүлээ.
Аудитын хязгаарлалт	Аудитын хязгаарлалт үүсээгүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБООС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1, 6817-5, 6817-7, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан шалгадагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд: ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль ✓ Төрийн аудитын тухай хууль ✓ Төсвийн тухай хууль ✓ СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Үндэсний аудитын газрын харьяа Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох нар гүйцэтгэв.

Аудитыг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, 2021 оны 07 дугаар сарын 09-нд аймгийн сонгуулийн хороонд хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

Халдварын цар тахал /ковид 19/-тай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор аймгийн сонгуулийн хорооны зарим албан хаагчдын тусгаарлагдсанаас мэдээлэл авахад цаг хугацааны хувьд хүндрэл үүссэн болно.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталж, 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулах аймгийн сонгуулийн хороог СЕХ-ны 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 40 дүгээр тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Аймаг, сумын 3 хороо, сонгуулийн 38 хэсгийн хороонд 342 ажилтан, мэдээлэл технологийн 44 даамал, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн 42 ажилтан ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг 273,106.0 мянган төгрөгөөр төсөвлөж, гүйцэтгэлээр 273,106.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

БҮЛЭГ 1. Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгох зардлыг бодитой, судалгаатай төлөвлөх шаардлагатай байна.

А.1. Улсын төсвөөс олгох сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлтийг бодитой, судалгаатай төлөвлөх шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Орхон аймгийн сонгуулийн хороонд 273,106.0 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан 273,106.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Сонгуулийн ерөнхий хороо баталсан хуваарийн дагуу шилжүүлсэн ба төсөв хуваарилахдаа төсвийн хуваарь, хуваарилсан төсвийн тайлбар, аргачлал, зөвлөмжийг тус бүр хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт 1 Аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан төсөв /мянган төгрөгөөр/

№	зардлын нэр	Төсөв 2021.04.12 3/71	Төсөв 2021.05.12 3/103	Төсөв 2021.05.31 1/124	Нийт төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	250			250.0
2	Бичиг хэргийн зардал	5,880			5,880.0
3	Шуудан холбооны зардал	7,000			7,000.0
4	Унааны зардал	21,450			21,450.0
5	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	450			450.0
6	МТБ, даамлын сургалтын зардал	1,450			1,450.0
7	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2,000			2,000.0
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	9,690	2,470		12,160.0
9	Сурталчилгааны зардал		5,000		5,000.0
10	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал		7,004		7,004.0
11	САС ашиглахтай холбоотой гарах зардал /эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/		1,710		1,710.0
12	Томилолтын зардал		1,552		1,552.0
13	Мэдээ дамжуулах унааны зардал		110		110.0
14	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал			173,910	173,910.0
15	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал			23,180	23,180.0
16	Болзошгүй зардал			10,000	10,000.0
	Нийт дүн	48,170.0	17,846.0	207,090.0	273,106.0

СЕХ-ноос нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан тооцсон хэдий ч зарим зардлыг хэмнэх судалгаа хийгээгүй байна. Тухайлбал:

1. Унааны зардлыг 1 километр 500 төгрөгөөр тооцсон нь Зам тээвэр, хөгжлийн сайдын 390 дүгээр тушаалаар баталсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-той нийцэхгүй байна. 100 километр 25 литр шатахуун /АИ-92, үнэ 1490 төгрөг/ зарцуулахаар тооцвол 1 километр 372.5 төгрөг ногдож байна. Мөн аймаг, сумын болон хэсгийн хороодод ажиллуулах автомашины тоог тогтоож өгөх хэрэгтэй байна.
2. Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардлыг зайлшгүй шаардлагатай хэсэгт хуваарилахаар заасан байх ба тухайн аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагад ашиглаж буй эрчим хүчний үүсгэврийн судалгааг ТӨБЗГ болон

орон нутгийн өмчийн газраас авч, түрээслэх эс үүсгэврийг тооцох боломжийг судлаагүй байна.

3. Төрийн далбаа бэлтгэх зардлыг сонгууль зохион байгуулах бүрд төлөвлөсөөр байгаа нь үргүй зардлыг өсгөж байна. Төрийн байгууллагуудад ашиглаж буй төрийн далбааны судалгаа хийж, төсвийг хэмнэх боломжийг судлаагүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулиар Орхон аймгийн сонгуулийн хороонд 215,869.5 мянган төгрөгийн төсөв хуваарилагдан зарцуулж байсан бол 2021 онд 57,536.5 мянган төгрөгөөр өссөн байна. Сонгуулийн хэсгийн хорооны ажилтны тоо 2017 оны сонгуулиас 51-ээр нэмэгдсэн нь урамшуулал, хоол, унааны зардалд нөлөөлсөн байна. Мөн болзошгүй зардал өмнөх сонгуулиас 7,000.0 мянган төгрөгөөс нэмэгдсэн байна.

Дүрслэл 1 Аймгийн сонгуулийн хорооны төсөв, нэрсийн жагсаалтад бүртгэлтэй хүний тоо



А.2 Аймгийн сонгуулийн хороо зардлыг журам, аргачлалын дагуу хуваарилсан байна.


Аймгийн сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын санхүүжилтийг СЕХ-оос 3 удаа олгож, тухай бүрд зардлын зүйл ангилал болон хөрөнгийг зарцуулах талаар холбогдох зөвлөмж, аргачлалыг ирүүлсэн байна.

СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3-т “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар, аргачлал, байгуулагдсан сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах зардлыг хуваарилна” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмж, аргачлалын дагуу 2 сумын сонгуулийн хороодод төсвийг хуваарилсан байна.

Нийт зардлын 77.8 хувь буюу 212,440.0 мянган төгрөгийг сумын сонгуулийн хороонд, 22.2 хувь буюу 60,666.0 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар хуваарилжээ.

Өмнөх сонгуулийн зардлын хуваарилалттай харьцуулбал сумын сонгуулийн хороодын зардлыг журам, аргачлалын дагуу тооцсоноор аймгийн сонгуулийн хорооны зардал буурсан байна.

Дүрслэл 2 Аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарилалт 2017, 2021 он



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9.2, 9.3, 9.4-т заасны дагуу УБЕГ-аас аймгийн УБХ-т 44,966.5 мянган төгрөг, ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газарт 16,243.0 мянган төгрөгийн санхүүжилт, ОБЕГ-аас ОБГ-т 38,938.2 мянган төгрөгийн хамгаалах хэрэгсэл, ариутгах бодис тус тус хуваарилсан байна.

БҮЛЭГ 2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулахад анхаарч, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Б.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ч арвилан хэмнэлттэй зарцуулахад анхаараагүй байна.

Аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан 273,106.0 мянган төгрөгөөс 2 сумын сонгуулийн хороо 212,440.0 мянган төгрөг, аймгийн сонгуулийн хороо 60,666.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, хэтрэлт, хэмнэлт үүсээгүй байна.

Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилагдсан төсвийг арвилан хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг анхан шатны баримттай тулган баталгаажуулсан бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн чиглэлийг баримталсан байна. Зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад зарим зөрчил илэрлээ. Үүнд:

- Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилагдсан байр бэлтгэх зардлаас 2 сумын сонгуулийн хороо 734.8 мянган төгрөгийн, болзошгүй зардлаас аймгийн сонгуулийн хороо 462.0 мянган төгрөгийн хөрөнгө авч, данс бүртгэлд тусгаагүй байна.
- Аймаг, сумын сонгуулийн хороодын унааны зардлын анхан шатны баримтын бүрдлийг хангуулсан хэдий ч аймгийн ЗДТГ-ын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн акт болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-оос өндөр дүнгээр тооцож, 2,000.6 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.
- Унааны зардлын анхан шатны баримт болох жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв, иж бүрэн хөтлөөгүй байна.
- Аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр сумын сонгуулийн хороо худалдан авсан бараа материалын тайланг нэгтгэн гаргаагүй, шаардах хуудас, орлогын баримт хөтлөөгүй байна.
- Бараа, ажил үйлчилгээ худалдан авсан е-баримтгүй 60.0 мянган төгрөгийн холбооны зардал, 50.0 мянган төгрөгийн болзошгүй зардал олгосон байна.
- Баян-Өндөр сумын сонгуулийн хороо нь бичиг хэрэг, санал авах байр, төрийн далбаа бэлтгэх зардлыг хэсгийн хорооны дарга нарын харилцах дансанд нийт 13,440.5 мянган төгрөг шилжүүлж олгосон байна.

Аймгийн сонгуулийн хорооноос унааны зардлыг НИК ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан шатахууныг талоноор авч, үнийн дүнгийн 3 хувиар тооцон 693.5 мянган төгрөгийн урамшуулал авч, хороодод хуваарилж, зарцуулсан байна.

Аймгийн УБХ, Цагдаагийн газар нь сонгууль зохион байгуулахтай холбоотой санхүүжилтийг байгууллагын харилцах дансаар авч зарцуулан, холбогдох дээд байгууллагууддаа тайлангаа нэгтгүүлсэн байх тул аудитад хамруулаагүй болно.

Б.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнажээ.

СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.1-т “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг НББ-ийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө” гэж заасны дагуу бүртгэж, тайлагнасан байна. Аймгийн сонгуулийн хороо

нь 2 сумын сонгуулийн хорооноос зарцуулалтын тайланг авч, нэгтгэсэн бөгөөд харилцах дансны хуулгатай тулган баталгаажуулахад тохирч байна.

Хүснэгт 2 Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр төрөл	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү /- хэмнэлт, +хэтрэлт/
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	250.0	250.0	-
2	Бичиг хэргийн зардал	5,880.0	5,880.0	-
3	Шуудан холбооны зардал	7,000.0	7,000.0	-
4	Унааны зардал	21,450.0	21,450.0	-
5	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	450.0	450.0	-
6	МТБ, даамлын сургалтын зардал	1,450.0	1,450.0	-
7	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	2,000.0	2,000.0	-
8	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	12,160.0	12,160.0	-
9	Сурталчилгааны зардал	5,000.0	5,000.0	-
10	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	7,004.0	7,004.0	-
11	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал /эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	1,710.0	1,710.0	-
12	Томилолтын зардал	1,552.0	1,552.0	-
13	Мэдээ дамжуулах унааны зардал	110.0	110.0	-
14	сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	173,910.0	173,910.0	-
15	Мэдээлэл технологийн багийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал	23,180.0	23,180.0	-
16	Болзошгүй зардал	10,000.0	10,000.0	-
Нийт		273,106.0	273,106.0	-

Б.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.4-т “СЕХ нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сумын сонгуулийн хороодын нягтлан бодогчдод хөрөнгө зарцуулах шийдвэрийг тухай бүр гаргах, эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, холбогдох тайлан мэдээ, санхүүгийн анхан шатны баримтыг НББ-ийн тухай хуулийн дагуу бүрдүүлж ажиллах зэрэг зааврыг тухай бүр өгч ажилласан байна. Гэсэн хэдий ч аймгийн сонгуулийн хороо бараа материалын тайлан гаргаагүй, анхан шатны баримтыг үнэн зөв хөтлөөгүй, Баян-Өндөр сумаас бараа материалын тайлангүй зардлын тайлан хүлээн авсан нь дотоод хяналтыг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумын сонгуулийн хорооны нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг шалгаж, акт үйлдэн хүлээн авсан байна.

Холбогдох байгууллагын санал:



**ОРХОН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,
Утас: 7035 3000, 9935 5775
И-мэйл: munkhbayar_5775@yahoo.com

2021.07.08 № 24
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орхон аймгийн Сонгуулийн хороо
тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй
болно.

ДАРГА  Д.СОЁЛЧХҮҮ

В.Шавзmaa
Тайланг зүгэлдэг.
 11/08

Саналд өгсөн тайлбар:

Аудитаар илэрсэн зөрчлүүдийг хүлээн зөвшөөрсөн тул тайланд засвар оруулах шаардлагагүй гэж үзлээ.